

Бодь Даатгал ХК-ийн ТУЗ-ийн  
2022 оны 02-р сарын 21-ний өдрийн  
22/10 тоот тогтоолын 2-р хавсралт



## **ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО /ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ/**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Бодь Даатгал ХКомпани (цаашид “Компани” гэх)-ны төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүнийг сонгон шалгаруулахад энэхүү зохицуулалтыг баримтална.

1.2. ТУЗ -ийн гишүүнийг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, ашиг сонирхлоос ангид байх, шударга, ил тод, хараат бус байх, эрх тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

1.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулахад энэхүү зохицуулалт болон Компанийн дотоод журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам зэргийг хамтад нь удирдлага болгоно.

### **Хоёр. Сонгон шалгаруулалт зохион байгуулах шийдвэр гаргах**

2.1. ТУЗ-ийн гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд Компани нь энэ тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

2.2. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурал гаргах бөгөөд уг ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг (цаашид “Ажлын хэсэг” гэх) Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын зөвлөмжөөр байгуулна.

2.3. Энэхүү журмын 2.2-т заасан шийдвэрт орон тоо гарсан ТУЗ-ийн гишүүнийг сонгох, сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа, удирдамж, шаардлагатай бусад асуудлыг тусгана.

### **Гурав. Ажлын хэсэг, түүний чиг үүрэг**

3.1. Энэхүү журмын 2.2-т заасан Ажлын хэсэг нь 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ. Ажлын хэсэгт Компанитай харилцан хамаарал бүхий 3-аас доошгүй гишүүн байна.

3.2. Ажлын хэсгийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга тус бүр саналын 1 эрхтэй байна.

3.3. Ажлын хэсэг сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хурлаараа хэлэлцэн тэмдэглэл үйлдэнэ.

3.4. Ажлын хэсэг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авч бүртгэх, хянах;

3.4.2. сонгон шалгаруулалттай холбоотой аливаа баримт бичиг, лавлагаа, мэдээллийг эрх бүхий байгууллага, бусад оролцогчдоос гаргуулан авах.

3.5. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.5.1. сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлаар Ажлын хэсгийн даргын удирдамжийн дагуу өдөр тутмын ажлыг зохион байгуулж, түүнийг мэдээллээр хангах;

3.5.2. сонгон шалгаруулалттай холбогдсон санал, хүсэлтийг хүлээн авч Ажлын хэсгийн даргад танилцуулах;

3.5.3. Ажлын хэсгийн хурлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах, хурлын тэмдэглэл, тогтоол үйлдэж гарын үсгийг зуруулан баталгаажуулах;

3.5.4. Ажлын хэсгийн даргаас өгсөн бусад чиг үүрэг.

#### **Дөрөв. Сонгон шалгаруулалтын тухай мэдээлэх**

4.1. Ажлын хэсэг нь байгуулагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ. Эсхүл Ажлын хэсгийн шийдвэрээр нийтэд үл мэдээлэн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулж болно.

4.2. Сонгон шалгаруулалтын зард ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуур, бүрдүүлэх материал, материал хүлээн авах хаяг, хугацаа, харилцах утасны дугаар болон шаардлагатай бусад мэдээллийг тусгана.

4.3. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацааг сонгон шалгаруулах тухай зарыг нийтэд мэдээлсэн эсвэл энэ журмын 5.3-5.4-т заасны дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлснээс хойш ажлын 5-аас доошгүй өдөр байхаар тогтооно.

#### **Тав. Материал хүлээн авах, бүртгэх**

5.1. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцогчдоос дараах баримт бичгийг энэ журмын 4.3-т заасан хугацааны дотор хүлээн авч бүртгэнэ:

5.1.1. Анкет, гурван үеийн намтар;

5.1.2. иргэний үнэмлэхийн хуулбар;

5.1.3. боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.1.4. 4х6 см хэмжээтэй 2 хувь цээж зураг;

5.1.5. нийгмийн даатгалын төлөлтийн лавлагаа;

5.1.6. сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;

5.1.7. оршин суугаа газрын тодорхойлолт;

5.1.8. иргэний ял шийтгэлтэй эсэх талаарх лавлагаа;

5.1.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 5.4 дэх хэсэгт заасан мэдээлэл;

5.1.10. Компанийн дүрмийн 8.7 дэх хэсэгт заасан мэдээлэл

5.1.11. Ажлын хэсгээс шаардлагатай гэж үзсэн бусад материал.

5.2. Энэ журмын 5.1-д заасан материал дутуу ирүүлсэн оролцогчийг бүртгэхгүй бөгөөд ирүүлсэн материалын үнэн зөвийг сонгон шалгаруулалтад оролцогч өөрөө хариуцна.

5.3 Энэхүү зохицуулалтад заасан мэдээллийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдээлсэн тохиолдолд ТУЗ-ийн гишүүнээс түдгэлзүүлж, чөлөөлнө.

### **Зургаа. Сонгон шалгаруулах ажиллагаа**

6.1. Сонгон шалгаруулах ажиллагаа нь Компанийн тухай хуульд заасан шалгуураас гадна боловсролын түвшин, мэргэшил, ур чадвар, туршлагыг нарийвчлан тогтооход чиглэгдэнэ.

6.2. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулах ажиллагааг анкетын болон ярилцлагын гэсэн 2 үе шаттайгаар зохион байгуулна.

6.3. Анкетыг үндэслэсэн шалгаруулалтын шатанд Ажлын хэсэг оролцогчдын материалыг хянан үзээд дараах байдлаар оноо өгч, нийлбэр дүнгээр 12 болон түүнээс дээш оноо авсан оролцогчийг дараагийн шатны буюу ярилцлагын шалгаруулалтад оролцуулна:

6.3.1. хуульд заасан шаардлага хангаж байгаа байдал: 0-10 оноо.

6.3.2. боловсрол, мэргэшил, туршлага, ур чадварын байдал: 0-10 оноо;

6.4. Ярилцлагын шалгаруулалтад оролцогчдод ярилцлагын үр дүнгээс хамаарч 0-10 оноо өгнө.

6.5. Сонгон шалгаруулалтад оролцогч нь 21 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд бүх оролцогчдийг сонгон шалгаруулалтад тэнцсэн гэж үзнэ.

6.6. Энэхүү журмын 6.3, 6.4-т заасны дагуу өгсөн онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан байдлаар сонгон шалгаруулалтад оролцогчдыг эрэмблэн жагсааж, дүнг гаргана.

6.7. Компани, даатгал, санхүүгийн бодлого боловсруулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

### **Долоо. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох**

7.1. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын дүнг холбогдох материалын хамт Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ба Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчид танилцуулж, шийдвэрлүүлнэ.

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тодорхой үндэслэлээр нэр дэвшигчийг томилохоос татгалзсан тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдоос дараагийн өндөр оноо авсан оролцогчийг нэр дэвшүүлж, эсвэл шинээр сонгон шалгаруулалт явуулна.